



ИРГЭДИЙН ОРЛОЦООНЫ
НЭГДЭЛ НАМ
ИОНН

Бүхнийг хүүхдийн төлөө!

ТЭД ЧАДСАНГҮЙ, ИРГЭД ЧАДНА!

ИОНН-ЫН МАНИФЕСТО

ХУЛГАЙЛЖ, ЦӨЛМӨЖ БОЛОХ БҮХ ЗҮЙЛИЙГ МАНЬХАН АВЛАА. ХАНСАНГҮЙ ЭЭ. ОДОО ИРГЭДИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ӨМЧ ХӨРӨНГӨ, УЛС ҮНДЭСТНИЙ СУУРЬ БОЛСОН ГАЗАР НУТАГ, ЗАЛУУ ҮЕИЙН ИРЭЭДҮЙ РҮҮ ХАЛДАХААР ЭЗЭЖ БАЙНА.

Эхлээд тэд үндсэн хуулийг өөрчлөн, улсын дээр нам, намын дээр дарга болон түүний эргэн тойрныхон зогсож, үндэсний бүх баялаг, газар нутаг, эрх мэдлийг эзэмшин, иргэд эх орноо түрээсэлж амьдардаг болгохыг хүссэн.

Тэр хүслийг иргэд сөрсөн тул биеллээгүй. гэвч хуулийн зүсийг хувирган баялгийн сан гэдэг сайхан нэртэй сан байгуулан, хүүхдийн мөнгө, хувьцааны ноогдол ашгийг зөвхөн өөрсдөө завших төлөвлөгөөг нэгэнт боловсруулсан байна. маньхан баялгийн сангийн тухай, газрын тухай, зөвшөөрлийн тухай, түгжрэлийн тухай хуулиудад санаагаа шингээн, сонгуулийн өмнө яаравчлан баталсан. одоо ялах л юм бол орон нутгийн сонгуулийн дараа бүхнийг авна хэмээн 2024 оны 10-р сарын 14-ний өдрийг тэсэн ядан хүлээж сууна.

Хамгийн түрүүнд түгжрэл бууруулах, утаа багасгах, орон сууцжуулах, малчдыг хоршоожуулах гэх мэт чихэр шиг гоё нэртэй, өндөр өртөгтэй төслүүд ярьж иргэдийн газрыг булааж авах бэлтгэлээ хангаж

байна. хоттой хонь үүр шөнөөр захаасаа чононд нэг нэгээрээ бариулдаг шиг гэр хорооллын газрыг сонгуулийн өмнө сэм сэмээр, нэг нэгээр нь түүгээд эхэлсэн. нэг л мэдэхэд хөршгүй болж үлдсэн айлуудыг ганцхан захирамж гаргаад газрыг нь хүчээр авах дадлагыг ман хийгээд эхэлжээ.

Булаасан газартаа өөрсдийн эзэмшдэг, өөрсдөд нь хамаатай ойр дотны, улс төрийг нь санхүүжүүлдэг компаниудад төсөл хэрэгжүүлэх эрх олгоно. зөвхөн газар, төсөл хэрэгжүүлэх эрх олгоод зогсоно гэж бодож байна уу. үгүй. тэд үргэлжлүүлээд монголын бүх иргэдийн төлж буй татвар, байгалийн баялгаас олох бүх орлогыг 9-хөн хүн удирддаг өнөөх баялгийн сандаа бөөгнүүлнэ. үүгээрээ нөгөөх л эрхээ олгосон компани, бизнесүүдээ дэмжинэ. харин үр дүнд нь хүүхдүүд мөнгөгүй, иргэд хувьцааны ноогдол ашиггүй, иргэд газаргүй, талхны мөнгө залгуулдаг бизнесгүй хоцроно. тэр 9 хүн хэний ч өмнө ямар ч хариуцлага хүлээхгүй, тэд иргэдээ сонгогдохгүй тул иргэдэд үйлчлэх албагүй. тэд унх-ын гишүүд биш тул үндсэн хуулийн бус аргаар улсын төсвийг төлөвлөж, захиран зарцуулах болно.

Нүүрс, алт, зэс гэх мэт ард түмний байгалийн баялгийн үнэ дандаа өндөр байхгүй гэдгийг маньхан мэдэж байгаа. үнэ буурчихвал яах вэ, төсөлд нь мөнгө дутвал яах вэ гэдгийг ч МАН-ынхан тооцсон. тэр үед нь ерөнхий сайд бүх баялгаа барьцаалан гадаадаас мөнгө зээлэх эрхийг ч мөн адил хуулинд оруулчихсан байгаа. тэгвэл барьцаа



нь юу байх юм бэ гэдэг асуулт зүй ёсоор гарч ирнэ. мэдээж газар нутаг, үндэсний баялагаа барьцаална. үр дүнд нь юу болох вэ? монгол улсын бүх иргэд эх орондоо хүний өмчийг түрээслэн, өр зээл, түрээсэнд дарлуулж амьдрана. товчхондоо монгол улсын иргэд эх орноо авилгачид, гадаадынхнаас түрээсэлж амьдрана. маньхан үр хүүхдүүдийн маань ирээдүйг баллуурдаж байна.

Харин, Иргэдийн Орлоцооны Нэгдэл Нам иргэдийнхээ ирээдүйдээ итгэх итгэлийг асааж, айх айдасгүй, хийж бүтээх, аюулгүй амьдрах

үндсэн эрхийг бүрэн эдлүүлэхийн төлөө энэ сонгуульд орж байна!

Эх орондоо түрээсгүй амьдрах аюулаас сэргийлж нийтийн баялгаас хэдхэн хүн давуу эрхээр хулгайлж байдаг тэгш бус байдлыг хална. үүний тулд сонгогдсон бол бизнесээ март, татвараас чөлөөлөгдөж, төрөөс тусгай зөвшөөрөл давуу эрх эдэлсэн бол ганцхан бизнес хий гэдэг зарчмыг хуульчилна. иргэдээ биш даргад үйлчилж, баг, хороо, дүүргийн түвшинд иргэдээ хянаж, хэн нэгний хараат болгох ажлыг зохион байгуулдаг засаг дарга нарыг

буцаан татах эрхийг иргэдийн гарт өгнө.


Ирээдүйг гэрэлтэй болгохын тулд 15 минут алхаад очих хүүхдэд ээлтэй ойрхон сургууль байгуулна. гуравхан цагийн дараа харих цаг нь болчихдоггүй, халуун хоолтой орчинд, хүүхэд цээжлэх гэж, багш нар цээжлүүлэх гэж зүдэрдэггүй сургалтыг олгохын төлөө бид ажиллана. ирээдүй эздийн төлөө энэ өөрчлөлтийг бид хийж чадна. бүхнийг хүүхдийн төлөө! иргэд чадна!

ИОНН ТООНЫ ХЭЛЭЭР


ГИШҮҮДИЙН ТОО:
6218

ХҮЙС


■ ЭМ ■ ЭР




НАСНЫ БҮТЭЦ



НЭР ДЭВШИГЧИД, ХҮЙСЭЭР



НЭР ДЭВШИГЧИДИЙН НАСНЫ БҮТЭЦ



СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

ИРГЭДИЙН САЙН ДУРЫН ОРЛОЦОО



ҮНЭЛЖ БАРШГҮЙ

НАМААС НЭГ НЭР ДЭВШИГЧИД



1.3 САЯ ₮

НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДАЛ



**ДЭЭД ХЭМЖЭЭ
7.9 САЯ ₮**



MASS MEDIA

SOCIAL NETWORK



БУСАД ЗАРДАЛ

0 ₮

ХОЁР НАСТАЙ ИОНН-ЫН ОНЦЛОХ 10 АЖИЛ

1 | АРДЧИЛСАН ҮНДСЭН ХУУЛИА АВЧ ҮЛДЭВ

Ардчилсан Үндсэн хуулиа авч үлдэв. 2023 оны 2, 3 дугаар сард Ардчилсан Үндсэн хуулиа авч үлдэхийн төлөө хоёр сарын тэмцэл өрнүүлэв. Энэ тэмцэлд Иргэдийн Орлоцооны Нэгдэл Нам ганцаардаж байсан юм. Харин УИХ-аас зохион байгуулсан хэлэлцүүлэгт ирсэн 1500 орчим иргэн саналаа өгөхдөө ИОНН-ын байр суурийг дэмжсэнээр ардчилсан Үндсэн хуулиа авч үлдэж чадлаа.



2 | ҮГ ХЭЛЭХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ТӨР НОЁРХОХ ГЭЖ БАЙСАН ХУУЛИНД ХОРИГ ТАВИУЛАВ

Нийгмийн сүлжээнд эрх чөлөөгөө авч үлдэв. 2023 оны 1-р сард ИОНН нийгмийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хэмээх хуулийн төслийг эсэргүүцэн давалгаа өрнүүлсний үр дүнд хуульд Ерөнхийлөгч хориг тавив.



3 | ХҮҮХДИЙН МӨНГИЙГ ХҮҮХЭД БҮРТ ОЛГУУЛАВ

Хүүхдийн мөнгийг тэмцэж олгуулав. 2023 оны 1-р сарын 1-нээс эхлэн 10 хүүхэд тутмын 1-д мөнгө өгөхгүй болсныг Иргэдийн Орлоцооны Нэгдэл Нам эсэргүүцэн, "Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт" жагсаалыг Сүхбаатарын талбайд зохион байгуулж, Үндсэн хуулийн цэцэд хандаж амжилтанд хүрлээ.



4 | ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЭСРЭГ ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ӨРГӨДӨЛ ГАРГАХ ЭРХИЙГ АВЧ ҮЛДЭВ

Иргэний Үндсэн Хуулийн Цэцэд гомдол гаргах эрхийг авч үлдэв. УИХ, Засгийн газар, Дээд шүүх, Прокурын өндөр албан тушаалтнууд Үндсэн хууль зөрчвөл иргэн гомдол гаргах эрхийг хүчингүй болгохоор Засгийн газар санаачилсныг эсэргүүцэж иргэдийнхээ эрхийг авч үлдэж чадав.



5 | УИХ-Д 152 ГИШҮҮНТЭЙ БОЛОХ ГЭСЭН САНААРХЛЫГ ЭСЭРГҮҮЦЭЖ БУУРУУЛАВ

УИХ-ын гишүүдийн тоог 152 болгохыг эсэргүүцэж бууруулав. Улс төрийн намуудаас ганцхан ИОНН 152 гишүүнтэй болохыг хүчтэй эсэргүүцсэн билээ. Бидний тэмцлийг иргэд дэмжиж байв. Үр дүнд нь гишүүдийн тоо 126 болж буурав.



6 | ХОТЫН ТӨВӨӨР 27К ТӨЛЖ ЯВДАГ БОЛОХ ГЭЖ БАЙСНЫГ ЭСЭРГҮҮЦЭЖ БОЛИУЛАВ

Улаанбаатар хотын төвөөр 27500 төгрөгийн татваргүйгээр зорчих эрхээ авч үлдэв. Иргэд хотын төвөөр зорчих бүртээ 27500 төгрөгийн татвар төлөхөөр хуулийн төслийг Засгийн газар зэхсэн байлаа. ИОНН эрс эсэргүүцэж гарын үсэг цуглуулах аян, эсэргүүцлийн мэдэгдлийг гаргасны үр дүнд иргэд чөлөөтэй зорчих эрх хэвээр үлдэв.




7 | ИРГЭНИЙ НИЙГМИЙГ ЕРӨНХИЙ САЙДЫН ХЯНАЛТАД ОРОХООС ХАМГААЛЖ АВЧ ҮЛДЭВ

Иргэний нийгмээ авч үлдэв. 2022 онд ИОНН Холбоо, Сангийн тухай хуулийг эсэргүүцэн тэмцсэний үр дүнд иргэний нийгэм, эрх чөлөөгөө авч үлдэв.




8 | УЛС ТӨРИЙГ БАГА ЗАРДАЛТАЙ БОЛГОВ

Улс төрийг бага зардалтай болгов. Жирийн дундаж орлоготой иргэн, залуучууд улс төрд орох, сонгогдох эрхээ эдлэх баталгааг бий болгохын тулд намынхаа бүх үйл ажиллагааг төлбөрийн чадварт нийцүүлэв.



9 | ЭМЭГТЭЙЧҮҮД КВОТГҮЙГЭЭР ОЛОНХ БОЛОВ

Эмэгтэйчүүд квотгүйгээр олонхи болов. Намын дотоод ардчилал, мэдээллийн хүртээмжийг цахим технологи, нээлттэй соёл нэвтрүүлэн нэмэгдүүлснээр ямарваа квотгүйгээр эмэгтэйчүүд намын шийдвэр гаргах бүх түвшинд олонхи болов.



10 | 100 ДАВСАН САЛБАРТАЙ 3 ДАХЬ НАМ БОЛОВ

Орон нутгийн иргэдийг улс төрд оролцуулав. Хоёр жилийн хугацаанд 121 анхан шатны салбар байгуулж, 3 аймаг, 9 дүүрэг болон нийслэлд танхимтай болсноор нийт 133 салбар, танхимтай болов.





Улсын их хурлын ээлжит 9 дэх удаагийн сонгуульд ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ (ИОНН)-аас нэр дэвшигчид

Нэг. Тойрогт нэр дэвшигчид
О Р О Н Н У Т А Г Т

У Л А А Н Б А А Т А Р Т

1 дүгээр тойрог. Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймагт:



Түвшинтөрийн ТҮВШИНЖАРГАЛ, Мягмарпүрэвийн ОСОРЖАМАА, Далхаагийн БАС-ОРГИЛ, Пүрэвжамбын САНЧИР

2 дугаар тойрог. Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймагт:



Батхолоогийн НЯМДОЛГОР, Лхагвасүрэнгийн ТӨМӨРСҮХ, Сэнгэсамбын МӨНХ-ОЧИР, Нялхайн ОЮУНДАЛАЙ



Ганжуурын МӨНХЦЭЦЭГ

4 дүгээр тойрог.

Булган, Орхон, Хөвсгөл аймагт:



Даваажавын БАТЧИМЭГ, Даваажавын ӨЛЗИЙ-ОРШИХ



Батмөнхийн АЮУШ



Хурмаашийн БААСАНСҮРЭН



Галбадрахын АЛТАНШАГАЙ



Лхагваагийн САРАНЧИМЭГ

5 дугаар тойрог. Дархан-уул, Сэлэнгэ, Төв аймагт:



Батбаярын ДАВААЖАРГАЛ, Дулмаагийн УУГАНБАЯР, Намдагийн НАРАНБААТАР, Гантөмөрийн ТУНГАЛАГ



Цэрэнбатын ДАВААДОРЖ



Зоригтын БАТ-ҮД



Баяртсайханы БЯМБАГЭРЭЛ



Намсрайн ЭРДЭНЭСЦАЦРАЛ

6 дугаар тойрог. Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт:



Ганхүүгийн ХҮРЭЛХҮҮ, Мягмарсүрэнгийн ОДГЭРЭЛ, Хүрэлбаатарын ЧИНЗОРИГ

7 дугаар тойрог. Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймагт:



Олзвойгийн ТОГТОХЗАЯА, Башлигийн НЯМХҮҮ, Чогдогийн БЯМБАЦЭРЭН, Очирхүүгийн АЛТАНБАЯР, Бямбажавын ӨЛЗИЙХИШИГ

8 дугаар тойрог. Баянзүрх дүүрэгт:



Батбаярын АРИУНЗАЯА, Дашцоодолын ХАНДСҮРЭН, Цогбадрахын БАТБОЛД, Түүчинтавын ДОРЖГОТОВ

9 дүгээр тойрог. Баянгол дүүрэгт:



Бат-Эрдэнийн ЦЭРЭНЛХАМ, Мөнхтоогогийн БЯМБАБАТ, Дорждэрэмийн ЭРДЭНЭТУЯА, Буяндалайгийн БЯМБАСҮРЭН

10 дугаар тойрог. Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт:



Зоригийн ТУЯА, Дугаржавын АРИУНАА, Мягмардашийн ОРХОНБАЯР, Хүрэлбаатарын ЗОРИГ



Базарбидарьяагийн ДОРЖСҮРЭН



Төмөрхуягийн ӨГӨӨМӨРЗАЯА

11 дүгээр тойрог.

Сонгинохайрхан дүүрэгт:



Шагдарын ӨЛЗИЙТОГТОХ



Чүлтэмсүрэн ЧУНТ, Ичинжорлоогийн САРАНГЭРЭЛ, Тогоогийн ГАНБАТ, Ажиршавгааны ЭНХБААТАР

12 дугаар тойрог. Хан-Уул дүүрэгт:



Цэдэвдамбын ОЮУНГЭРЭЛ, Пүрэвдоржийн БАЯРТҮВШИН, Чулуунбатын БАТЧИМЭГ

13 дугаар тойрог. Багахангай, Багануур, Налайх дүүрэгт:



Чулуунтогтохын ГАНСҮРЭН, Мөнхтуяагийн ОЮУНХИШИГ

Хоёр. Намын жагсаалтаар нэр дэвшигчид



Мөнхжаргалын МӨНХЦЭЦЭГ, Балдирын ТӨРХҮҮ



Раднаажавын ОТГОНЧИМЭГ, Дамчаагийн НАРАНБААТАР

